



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Дарвисумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2023/101/НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2023 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Гэрэлт Хөхийн тэнцвэр Аудит ХХК-ны Ховд дахь салбар

Аудитор: Д.Хишгээ

Утас: 70432545

цахим хаяг: hishgee.da @ gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
Асуудлыг онцолсон хэсэг	3Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал	3Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ...	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5.1 Завсрын аудитын талаар	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	Error! Bookmark not defined.
5.1 Төлбөрийн акт	13
5.2 Албан шаардлага:	13Error! Bookmark not defined.
5.3 Зөвлөмж.....	Error! Bookmark not defined.4
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	Error! Bookmark not defined.5

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн Тайлангийн Аудит
НА	Нотлох Ажил
ТШЗ	Төсвийн Шууд Захирагч



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2022.08.20 № 268
танай _____ -ны № _____ -т

ХОВД АЙМГИЙН ДАРВИ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Д.СОЁЛМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Дарви сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэхбайгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын салбар төсвийн шинэчлэлийн хүрээнд сургуулийн санхүүгийн эрх мэдэл, хувьсах зардал, сургуулийн бүтэц, хэв шинжийн шинэчлэл, сургалтын чанарт суурилсан цалин урамшууллын тогтолцоог бий болгосон байна.

Багш нарын цалинг ТҮ-5 ангиллаар олгосон, хувьсах зардлын тухайд багшийн эрүүл мэндийн үйлчилгээ, дата хэрэглээний зардал, хичээл практикийн зардал, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн зардлыг тусгаж, төлөвлөх, зарцуулах аргачлалыг Засгийн газрын 2022 оны 91 дугаар тогтоолоор баталж мөрдсөн байна.

Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 18 дугаартай чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 9,7 сая төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлээгүй байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Засгийн Газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын нормативын хэмжээг шинэчлэн тогтоосон. Боловсрол Шинжлэх ухааны сайдын 2022 оны А/500 дугаар тушаалаар сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэгдэл урамшуулал олгосон байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06 -ны өдрийн А/192 дугаар тушаалын хавсралтын дагуу илүү цагийн хөлсийг олгохдоо дундаж цалин хөлс тооцох журмыг баримтлаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус цэцэрлэг нь 2022 онд нийт 178 хүүхэд сургахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 178 хүүхэд сургаж биелэлт 100 хувьтай байна.

7 бүлэг 35 заалт бүхий ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засаг даргаар баталгаажуулж үр дүнг тооцож, 98 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Х.БОЛДБААТАР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>58,965,095.00</u>	<u>72,000,074.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	9,727,718.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	9,727,718.00
3121	Төгрөг	-	9,727,718.00
31211	Төрийн сангийн харилцах	-	9,727,718.00
35	БАРАА МАТЕРИАЛ	58,965,095.00	62,272,356.00
351	Түүхий эд материал	565,800.00	-
35130	Эм боох материал	565,800.00	-
35300	Бэлэн бүтээгдэхүүн	396,139.00	-
354	Хангамжийн материал	58,003,156.00	62,272,356.00
35410	Бичиг хэргийн материал	745,000.00	-
35460	Хүнсний материал	12,617,800.00	8,464,500.00
35470	Бусад хангамжийн материал	44,640,356.00	53,807,856.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,838,022,216.75</u>	<u>1,844,361,460.36</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,838,022,216.75	1,844,361,460.36
392	Биет хөрөнгө	1,832,540,216.79	1,839,004,460.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,896,887,149.00	1,945,748,772.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(131,754,721.48)	(181,629,769.24)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	46,305,947.00	51,617,947.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(28,938,133.89)	(35,599,791.73)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	57,944,567.00	76,914,567.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,156,090.92)	(38,393,764.71)
39214	Бусад үндсэн хөрөнгө	29,325,000.00	29,325,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,084,999.92)	(8,989,999.88)
39217	Ном	11,500.00	11,500.00
393	Биет бус хөрөнгө	5,481,999.96	5,356,999.92
39301	Програм хангамж	625,000.00	625,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(125,000.04)	(250,000.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,982,000.00	4,982,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,896,987,311.75</u>	<u>1,916,361,534.36</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,896,987,311.75</u>	<u>1,916,361,534.36</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,896,987,311.75	1,916,361,534.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	320,566,276.00	320,566,276.00
512	Хуримтлагдсан үр дүн	969,381,562.92	988,755,785.53
51210	Өмнөх үеийн үр дүн	969,381,562.92	969,381,562.92
51220	Тайлант үеийн үр дүн	-	19,374,222.61
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	607,039,472.83	607,039,472.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,896,987,311.75</u>	<u>1,916,361,534.36</u>

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	395,635,739.0	558,135,323.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	78,755,323.0
120	Нийтлэг татварын бус орлого	-	73,143,623.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	73,143,623.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	73,143,623.0
122	Тусламжийн орлого	-	5,611,700.0

122001	Хандив тусламж /дотоод/	-	5,611,700.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	395,635,739.0	479,380,000.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	359,454,200.0	417,836,900.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	417,836,900.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	35,398,900.0	61,543,100.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,398,900.0	61,543,100.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	455,009,699.7	538,761,100.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	455,009,699.7	538,761,100.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	395,984,057.7	532,280,990.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	249,321,004.2	312,071,633.0
210101	Үндсэн цалин	170,400,420.1	221,089,411.0
210102	Нэмэгдэл	46,964,982.0	66,474,916.0
210104	Урамшуулал	27,789,871.0	24,507,306.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,753,967.1	39,113,939.0
210201	Тэтгэврийн даатгал	21,046,773.3	29,863,407.6
210202	Тэтгэмжийн даатгал	2,476,090.7	3,141,716.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,974,152.6	2,503,293.2
210204	Ажилгүйдлийн даатгал	487,300.2	613,875.4
210205	Эрүүл мэндийн даатгал	769,650.3	2,991,646.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,992,907.0	45,530,900.0
210301	Гэрэл, цахилгаан	2,892,907.0	3,927,255.0
210302	Түлш, халаалт	30,100,000.0	41,603,645.0
2105	Нормативт зардал	16,063,100.0	52,406,539.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,929,300.0	396,139.0
210502	Хоол, хүнс	13,133,800.0	52,010,400.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	160,000.0	160,000.0
210604	Урсгал засвар	160,000.0	160,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	324,000.0	1,050,150.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.0	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,050,150.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,787,779.4	81,947,829.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,000.0	8,918,450.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,883,400.0	6,225,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66,804,379.4	66,804,379.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,025,642.0	6,480,110.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	3,695,200.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,695,200.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	59,025,642.0	2,784,910.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	59,025,642.0	2,784,910.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(59,373,960.7)	19,374,222.6
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(59,373,960.7)	19,374,222.6

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	320,566,276.0	607,039,472.8	969,381,562.9	1,896,987,311.8
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	320,566,276.0	607,039,472.8	969,381,562.9	1,896,987,311.8
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	58,386,037.2	58,386,037.2
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	320,566,276.0	607,039,472.8	1,027,767,600.1	1,955,373,348.9

D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	320,566,276.0	607,039,472.8	1,027,767,600.1	1,955,373,348.9
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	320,566,276.0	607,039,472.8	1,027,767,600.1	1,955,373,348.9
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	19,374,222.6	19,374,222.6
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	320,566,276.0	607,039,472.8	1,047,141,822.7	1,974,747,571.5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	395,635,739.0	479,380,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	395,635,739.0	479,380,000.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	359,454,200.0	417,836,900.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	417,836,900.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	359,454,200.0	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	782,639.0	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	782,639.0	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	35,398,900.0	61,543,100.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,398,900.0	61,543,100.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	395,635,739.0	469,652,282.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	395,635,739.0	469,652,282.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	336,610,097.0	463,172,172.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	244,249,072.0	312,071,641.0
210101	Үндсэн цалин	164,885,803.0	263,945,154.0
210102	Нэмэгдэл	68,304,187.0	45,270,783.0
210104	Урамшуулал	11,059,082.0	2,855,704.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,196,179.0	39,113,931.0
210201	Тэтгэврийн даатгал	21,997,579.0	31,318,869.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,549,500.0	1,955,879.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,039,700.0	1,583,443.1
210204	Ажилгүйдлийн даатгал	510,000.0	397,845.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,099,400.0	3,857,894.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,992,907.0	45,530,900.0
210301	Гэрэл, цахилгаан	2,892,907.0	3,927,255.0
210302	Түлш, халаалт	30,100,000.0	41,603,645.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,950,139.0	-
210402	Тээвэр, шатахуун	1,002,800.0	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	757,639.0	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	189,700.0	-
2105	Нормативт зардал	22,424,400.0	47,857,100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,062,800.0	-
210502	Хоол, хүнс	19,556,600.0	47,857,100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	805,000.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	160,000.0	160,000.0
210604	Урсгал засвар	160,000.0	160,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	324,000.0	1,050,150.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.0	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,050,150.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,313,400.0	17,388,450.0

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,000.0	12,108,450.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,213,400.0	5,280,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,025,642.0	6,480,110.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	3,695,200.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,695,200.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	59,025,642.0	2,784,910.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	59,025,642.0	2,784,910.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	9,727,718.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	9,727,718.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	9,727,718.0

2.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	479,650,000.0	466,867,372.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	479,650,000.0	466,867,372.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	475,954,800.0	463,172,172.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	316,038,900.0	312,071,641.0
210101	Үндсэн цалин	267,912,413.0	263,945,154.0
210102	Нэмэгдэл	45,270,783.0	45,270,783.0
210104	Урамшуулал	2,855,704.0	2,855,704.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,505,200.0	39,113,931.0
210201	Тэтгэврийн даатгал	31,710,138.0	31,318,869.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,955,879.3	1,955,879.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,583,443.1	1,583,443.1
210204	Ажилгүйдлийн даатгал	397,845.0	397,845.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,857,894.6	3,857,894.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,530,900.0	45,530,900.0
210301	Гэрэл, цахилгаан	3,927,255.0	3,927,255.0
210302	Түлш, халаалт	41,603,645.0	41,603,645.0
2105	Нормативт зардал	56,224,000.0	47,857,100.0
210502	Хоол, хүнс	56,224,000.0	47,857,100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	160,000.0
210604	Урсгал засвар	-	160,000.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,110,000.0	1,050,150.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,110,000.0	1,050,150.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,545,800.0	17,388,450.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,265,800.0	12,108,450.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,280,000.0	5,280,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,695,200.0	3,695,200.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,695,200.0	3,695,200.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,695,200.0	3,695,200.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	479,650,000.0	476,595,090.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	417,836,900.0	417,836,900.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	417,836,900.0	417,836,900.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	61,543,100.0	58,758,190.0
132001	Орон нутгийн төсвөөс	61,543,100.0	58,758,190.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		9,727,718.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүүхдийн нийгэм сэтгэл зүй танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, сургалт үйл ажиллагааг чанар үр дүнтэй зохион байгуулах үндсэн зорилготойгоор Дарви сумын сургуулийн өмнөх боловсрол олгох 112 хүүхэд, хувилбарт 23 хүүхдийг хамруулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа СӨБ-ийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- “Хувьсах зардлын дундаж норматив тогтоох тухай” Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол;
- “Хичээл, сургалтын үйл ажиллагаа, Багшийн тасралтгүй хөгжил, цахим хэрэглээ, тоног төхөөрөмж нөхөн хангалт батлах тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаал;
- “Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах тухай журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/465 дугаар тушаал;
- “Төрийн болон орон нутгийн өмчийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар үр дүн үнэлж, үр дүнгийн урамшуулал олгох журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/500 дугаар тушаал тус тус шинэчлэгдэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний

үр дүнд дотоод хяналтын ажилтан томилсон, дотоод хяналтын баг өдөр тутмын үйл ажиллагаандаа хяналт хэрэгжүүлж ажилладаг байна. Иймд дотоод хяналтын хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэлээ.

Тайлант онд БШУЯ-ны дотоод аудитын алба болон аймгийн ЗДТГ-ын Санхүү, дотоод аудитын албанаас тус сургуулийн 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2017 онд баталсан бөгөөд шинээр батлагдсан холбогдох хууль, дүрэм, журам, заавар аргачлалын дагуу өөрчлөлтийг тусгасан байгаа нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дарви сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19.4 сая төгрөгөөр буюу 1 хувиар өссөн байна. Өмнөх оноос мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэлд өөрчлөлт орсон байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	9.7	9.7
Авлага	-	-	-
Бараа материал	59.0	62.3	3.3
Үндсэн хөрөнгө	1,838.0	1,844.4	6.3
Нийт хөрөнгө	1,897.0	1,916.4	19.4
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,897.0	1,916.4	19.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,897.0	1,916.4	19.4

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25 өдрийн 18 дугаартай албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 9,7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- ✓ Тайлант онд Авлага өглөггүй ажилласан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 417,8 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 61,5 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 0,3 сая төгрөг, зарлагыг **479,7** сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Боловсролын салбар нь үр дүн гүйцэтгэлд суурилсан төсвөөр төсвөө боловсруулснаар цалингийн зардлыг 29.3 сая төгрөгөөр, бусад урсгал зардлыг 11.2 сая төгрөгөөр өсгөж баталсан байна. Тайлант оны батлагдсан төсвийг 40.4 сая төгрөгөөр өсгөж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр 417.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 61,5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 0,3 сая төгрөгийг үйл ажиллагааны орлого бүрдүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 417.8 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 58.8 сая төгрөг, нийт 476.6 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, орон нутгийн төсөвт 2,7 сая төгрөгийг төвлөрүүлэн, 9,7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 466.9 сая төгрөг буюу 98.0 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 4,2 сая төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 8,4 сая төгрөгөөр, тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөг/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80111	Барилгын тогтмол зардал	45.5	45.5	-	100%
80112	Нийтлэг үйлчилгээ	17.5	17.4	0.1	99%
81605	Эрүүл мэндийг дэмжих	1.5	1.5	-	100%
81807	Хүүхдийн хоол	56.2	47.9	8.3	85%
81816	Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	5.3	5.3	-	
81823	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1.5	1.5	-	100%
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр	3.7	3.7	-	
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	345.4	344.1	1.3	100%
	дүн	479.7	466.9	9.7	98%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Дарви сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Гэрэлт Хөхийн тэнцвэр аудит ХХК-ны Ховд дахь салбарын аудитор Д.Хишгээ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар хэрэгжүүлсэн.

Ховд аймгийн Дарви сумын Хүүхдийн цэцэрлэг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дүгээр сарын 08 -ны өдрийн . 14 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыгсонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 357,4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7,1 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд 2022 оны санхүүгийн тайлангийн нийт 558.1 сая төгрөгөөр 2 хувиар буюу 11.1 сая төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар тооцон 8.9 сая төгрөгөөр дахин хянаж шинэчлэн тогтоосон болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Аудитаар төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 6 горим сорил хэрэгжүүлсний үр дүнд илэрсэн зөрчлийн дэлгэрэнгүйг тайлангийн 5-д дэлгэрэнгүй оруулсан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, таван саяас дээш орлого, зарлагын гүйлгээг бүрэн мэдээлж, 44 тушаал шийдвэрээс 44-ийг бүрэн мэдээлж, хуулийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авч , 1 заалт бүхий 1 зөвлөмжийг бүрэн биелүүлсэн бөгөөд Аудитын шийдвэрийн нийт биелэлт 100 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Илрүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	2.4	1	2.4	100
Нийт дүн	1	2.4	1	2.4	100

/сая төгрөг/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, оны эцэст салбарын зохион байгуулдаг худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг анхаарч үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/ алдаа зөрчил илэрсэнгүй.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР: Д.ХИШГЭЭ

Дараагийн аудитаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, оны эцэст салбарын зохион байгуулдаг худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг анхаарч үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/ алдаа зөрчил илэрсэнгүй.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР: Д.ХИШГЭЭ